



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Өргөн сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/51/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi.audit.mn

Сайншанд хот
2020 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734 Цахим хаяг: Dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Энхцэцэг

Утас: 70523020 Цахим хаяг:

Аудитор: О.Нарангарав

Утас: 70523020 Цахим хаяг:
Narangarav.o@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.12. Шилэн дансны мэдээлэл	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Менежментийн захидал	11
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.2 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	20

Аудитын гэрчилгээ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2020.02.27 № 1-6/118

танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ӨРГӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
О.ЦАСАНЦЭЦЭГ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Өргөн сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Өргөн сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Өргөн сумын Засаг даргын тамгын газар нь 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

010020019

Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Өргөн сумын Засаг даргын тамгын газар нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Өргөн сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг байгууллагын дарга О.Цасанцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Өргөн сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Өргөн сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 19-аас 2020 оны 02 дүгээр сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор О.Нарангарав хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Өргөн сумын даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 06/29 дугаар бүхий албан бичгээр 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорноговь аймгийн Өргөн сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Сум багийн ажлыг уялдуулан оновчтой бодлого зохицуулалтаар хангах замаар аймгийн хөгжилд дэмжлэг үзүүлж, улмаар төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэж төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэхэд чиглэгдэнэ”-д оршино.

Дорноговь аймгийн Өргөн сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэж төрийн үйлчилгээг хүргэх

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорноговь аймгийн Өргөн сумын Засаг даргын тамгын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Өргөн сумын Засаг даргын тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Өргөн сумын Засаг даргын тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 5 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 380,873.5 мянган төгрөгөөс тооцон 3,808.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 5,320.3 мянган төгрөгөөр тооцсон нь материаллаг байдлыг 2019 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр тооцсон тул өөрчлөн 2019 оны жилийн эцсийн тайлангаар материаллаг байдлыг тодорхойлох нь зүйтэй гэж үзэн нийт зардлын 1%-иар тодорхойлов.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Өргөн сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 87,191.6 мянган төгрөгөөр буюу 4.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө 1,050.0 мянган төгрөг, авлага 1,749.2 мянган төгрөг, бараа материал 34,743.2 мянган төгрөг, цэвэр үндсэн хөрөнгө 49,648.9 мянган төгрөг, өр төлбөр 3,002.3 мянга төгрөг, цэвэр хөрөнгө өмчийн дүн 84,189.3 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/	
				Зөрүү	
				Дүн	Хувь
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	109,690.27	147,232.94	37,542.68	34.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	1,050.00	1,050.00	-
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-	-	-
33	АВЛАГА	7,191.06	8,940.31	1,749.25	24.3
34	УРЬДЧИЛГАА	-	-	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	102,499.21	137,242.63	34,743.42	33.9
36	НӨӨЦИЙН БАРАА	-	-	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,678,527.09	1,728,176.03	49,648.94	2.9
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,678,527.09	1,728,176.03	49,648.94	2.9
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,788,217.36	1,875,408.97	87,191.61	4.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,043.30	4,045.60	3,002.30	287.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,043.30	4,045.60	3,002.30	287.7
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,787,174.06	1,871,363.38	84,189.31	4.7
	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,788,217.36	1,875,408.97	87,191.61	4.8

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,050.0 мянган төгрөгөөр өссөн нь ахмадын сангийн дансны үлдэгдэл харилцах дансанд үлдсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 1,749.2 мянган төгрөгөөр өссөн нь өмнө оны авлага 2,749.6 мянган төгрөгөөр буурч, тайлант онд 864.0 мянган төгрөгийн түрээсийн авлага, 3,634.8 мянган төгрөгийн хувь хүнээс өвс авах авлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 34,743.4 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэрэг 295.5 мянган төгрөг, аж ахуйн материал 33,32.7 мянган төгрөг, мал амьтанд 615.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материалын өсөлтөд 7,285.2 мянган төгрөгийн өвс, 26,080.0 мянган төгрөгийн ногоон зүлэг худалдан авч данс бүртгэлд тусгасан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл нь авто тээврийн хэрэгсэл 32,670.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 23,221.1 мянган төгрөг, тавилга эд хогшил 4,767.0 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 134,451.5 мянган төгрөг, программ хангамж 605.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 6,184.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 97,700.0 мянган төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 32,670.0 мянган төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 53,673.8 мянган төгрөг, хандив тусламжаар 5,486.1 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, бусад хөрөнгийг нэмж бүртгэсэн байна.

Биет бус хөрөнгө 605.0 мянган төгрөгөөр өссөн нь архивын бүртгэлийн программ, нярвын бүртгэлийн программ хангамжийг худалдан авсантай холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгөнд нийт 146,065.7 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг тооцож цэвэр үндсэн хөрөнгө нийт дүнгээрээ 49,648.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 3,002.3 мянган төгрөгөөр өссөн нь өмнө оны өр төлбөр 352.0 мянган төгрөгөөр буурч, тайлант онд 3,354.3 мянган төгрөгийн түлш халаалтын өр төлбөртэй ажилласантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,871,363.4 мянган төгрөг болж 84,189.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэн нь шалтгаалжээ. Энэ нь тайлант онд хөрөнгө оруулалтаар хөрөнгө нийлүүлэгдсэнтэй холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Өргөн сумын Засаг даргын тамгын газарт тайлант онд 5,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 4,873.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 97.5 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Дансны код	Орлогын ангилал	Тайлант оны		Тайлант оны зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1310	Орон нутгийн төсвөөс санхүүжих	372,698.10	372,708.10	(10.00)	100.00
122	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	5,000.00	4,873.50	126.50	97.47
	Нийт дүн	377,698.10	377,581.60	116.50	99.97

Туслах үйл ажиллагааны орлого 126.5 мянган төгрөгөөр тасарсан нь 1 түрээслэгч иргэн түрээсийн орлогыг бүрэн төлөөгүйгээс жилийн эцэст 864.0 төгрөгийн авлагатай гарсантай холбоотой байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 377,698.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 331,598.1 мянган төгрөгийг урсгал зардалд, 46,100.0 мянган төгрөгийг хөрөнгийг зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 372,698.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 5,000.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ. санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Орон нутгийн төсвөөс 372,708.1 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 4,873.5 мянган төгрөг нийт 377,581.6 мянган төгрөгийн санхүүжилттэй ажилласан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 373,837.3 мянган төгрөг буюу 99.0 хувьтай байна. Үүний: Албан хаагчдын цалин, НДШ-ийн зардал 233,572.4 мянган төгрөг нь нийт зардлын 62.5 хувь, бараа ажил үйлчилгээний бусад зардал 93,576.3 мянган төгрөг нь нийт зардлын 25.0 хувь, урсгал шилжүүлгийн зардал 800.0 мянган төгрөг нь нийт зардлын 0.2 хувь, хөрөнгийн зардал 45,888.6 мянган төгрөг нийт зардлын 12.3 хувийг тус тус эзэлж байна.

Жилийн эцэст санхүүжилтийн дутуу 116.5 мянган төгрөг, урсгал зардлын хэмнэлт 3,860.8 мянган төгрөгийн зөрүү хэмнэлт 3,744.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсөв: Аймгийн Статистикийн хэлтсээс мал тооллого, барилга орон сууцны тооллогын санхүүжилт 2,205.8 мянган төгрөг, ХХҮГ-аас ХАБЭА санхүүжилт 300.0 мянган төгрөг, АИТХ-аас төлөөлөгчийн тойргийн зардал болон ОНЦ-ын урамшуулал 6,047.7 мянган төгрөг, АЗДТГ-аас 30,000.0 мянган төгрөгийн дэмжлэг, 1,500.0 мянган төгрөгийн шагналын мөнгө зэргийг олгож, цахим тендерийн орлого 495.0 мянга, өвсний орлого 7,047.4 мянган төгрөг, өмнө оны татан төвлөрүүлэлтийн 2,284.2 мянган төгрөг нийт 23,030.7 мянган төгрөгийн орлогыг холбогдох дансанд бүтгэсэн байна.

Нийт санхүүжилтийн зарцуулах эрхийг зохих журмын дагуу нээлгэн холбогдох үйл ажиллагаануудад зарцуулсан байна. АЗДТГ-ын олгосон дэмжлэгээр наадмын талбайн тохижилтыг хийсэн байна.

Жилийн эцэст зарцуулагдаагүй үлдэгдэл 1,443.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 5 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 4 эрсдэл тодорхойлж нийт 9 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 9,601.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 4,688.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,558.9 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 3,354.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 4,913.2 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил илэрснээс 1,558.9 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 3,354.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой

Сумын ИТХ-ын 2019 оны 08/01, 08/02 дугаар тогтоолыг үндэслэн сумын Засаг даргын тамгын газрын даргын 2019 оны Б/33 дугаар тушаалаар сумын Засаг дарга Ж.Сүхбаатарт 438,420 төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна МУ-ын Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 40 дүгээр зүйлийн 40.1, 40.4.2 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

2. Балансын данстай холбоотой

Тайлант онд түлш халаалтын зардлын 3,354.3 мянган төгрөгийн өр төлбөртэй гарсан байна.

Энэ нь Оршин байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна, МУ-ын Төсвийн тухай хуулийн 5.1.3, 6.4.8 16.5.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

3. Зардлын данстай холбоотой

Сумын Засаг даргын тамгын газрын дарга О.Цасанцэцэг, Санхүү албаны дарга Э.Ононбайгаль нарт сумын Засаг даргын 2019 оны Б/02, Б/03, Б/07, Б/08 дугаар захирамжуудаар тус бүр 2 удаа сахилгын шийтгэл оногдуулсан байхад сумын Засаг даргын 2019 оны Б/12, Б/19 тоот захирамжуудаар сахилгын шийтгэлтэй байх хугацаанд 2019 оны 8 сар, 12 саруудад О.Цасанцэцэгт 606,885 төгрөг, Э.Ононбайгальд 513,605 төгрөг нийт 1,120,490 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Монгол улсын Төрийн албаны тухай хуулийн 48.6 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан Мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.1, 2.7 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

Аудитаар илэрсэн зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Мал амьтдын бүртгэлийг тодруулж авч үзэх шаардлагатай.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Өргөн сумын Засаг даргын тамгын газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 137 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 14 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Дорноговь аймгийн Өргөн сумын Засаг даргын тамгын газар нь өмнө онд 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг ирүүлээгүйгээс цаг хугацааны хязгаарлалтад орж дүгнэлт өгөхөөс татгалзсан учир акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Өргөн сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Өргөн сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Орлогын данстай холбоотой

1.1. Илрүүлэлт: Түрээсийн төлбөрийн 50%-ийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн боловч мөнгөн гүйлгээний тайланд тусгаагүй орлого бууруулан тайлагнасан байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1, 14.4 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалын “Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журам”-ын 3.9 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу тайлагнагдах эрсдэлтэй.

1.3 Өгсөн зөвлөмж: Цаашид холбогдох хууль, журмын дагуу түрээсийн орлогын тооцооллыг сар бүр хийж, НББ-д өглөг авлагыг бүрэн тусгаж, мөнгөн гүйлгээний тайланд орлого зарлагыг тайлагнаж байх.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгч буй зөвлөмжид санал байхгүй гэсэн хариу тайлбарыг баталгаажуулан ирүүлсэн байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	109,690,269.83	147,232,944.83
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	1,050,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	1,050,000.00
3121	Төгрөг	00.00	1,050,000.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	1,050,000.00
33	АВЛАГА	7,191,061.00	8,940,314.00
335	Бусад авлага	7,191,061.00	8,940,314.00
3351	Байгууллагаас авах авлага	4,903,287.00	2,626,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,287,774.00	6,314,314.00
35	БАРАА МАТЕРИАЛ	102,499,208.83	137,242,630.83
354	Хангамжийн материал	50,421,168.83	84,549,590.83
35410	Бичиг хэргийн материал	368,360.00	663,860.00
35420	Аж ахуйн материал	49,397,688.83	83,230,610.83
35450	Барилгын засварын материал	655,120.00	655,120.00
35600	Мал амьтад	52,078,040.00	52,693,040.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,678,527,089.64	1,728,176,026.30
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,678,527,089.64	1,728,176,026.30
392	Биет хөрөнгө	1,608,952,173.18	1,658,197,047.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	966,631,384.00	966,631,384.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-12,821,889.00	-45,610,225.32
39203	Авто-тээврийн хэрэгсэл	326,638,400.00	359,308,400.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-241,046,341.21	-273,715,957.69
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	69,623,354.48	92,844,504.48
39206	Хуримтлагдсан элэгдэл	-44,741,737.47	-49,702,225.34
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,451,871.92	40,218,871.92
39208	Хуримтлагдсан элэгдэл	-22,221,280.62	-25,915,457.89
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	8,005.69	8,005.69
39212	Хуримтлагдсан элэгдэл	-8,005.69	-8,005.69
39214	Бусад үндсэн хөрөнгө	887,531,314.13	1,021,982,832.13
39215	Хуримтлагдсан элэгдэл	-356,932,253.05	-428,684,429.01
39217	Ном	839,350.00	839,350.00
393	Биет бус хөрөнгө	69,574,916.46	69,978,979.02
39301	Програм хангамж	3,066,000.00	3,671,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,833,083.54	-3,034,020.98
39303	Бусад биет бус хөрөнгө	69,342,000.00	69,342,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,788,217,359.47	1,875,408,971.13
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,043,297.93	4,045,595.90
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,043,297.93	4,045,595.90
413	Өглөг	1,043,297.93	4,045,595.90
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	232,752.93	150,000.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	17,145.00	3,849,095.90
4136	Бусад өглөг	793,400.00	46,500.00
41361	Байгууллагад төлөх өглөг	439,500.00	34,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	353,900.00	12,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,787,174,061.54	1,871,363,375.23
51	Засгийн газрын хувь оролцоо	1,787,174,061.54	1,871,363,375.23
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	839,615,463.96	839,615,463.96
51101	Өмч: - төрийн	839,615,463.96	839,615,463.96
512	Хуримтлагдсан үр дүн	544,156,488.08	628,345,801.77
51210	Өмнөх үеийн үр дүн	544,156,488.08	541,720,601.08
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	86,625,200.69
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	403,402,109.50	403,402,109.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,788,217,359.47	1,875,408,971.13

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	454,527,566.33	618,651,322.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	149,204,692.33	198,347,268.00
120	Нийтлэг татварын бус орлого	149,204,692.33	198,347,268.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	149,204,692.33	198,347,268.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,858,811.00	5,737,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	138,345,881.33	192,609,768.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	305,322,874.00	420,304,054.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,070,074.00	47,595,954.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,070,074.00	37,547,717.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	10,048,237.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	300,252,800.00	372,708,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	300,252,800.00	372,708,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	427,635,196.69	532,026,121.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	427,635,196.69	486,137,535.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	416,680,461.31	478,799,498.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	182,311,232.55	206,405,706.35
210101	Үндсэн цалин	180,561,232.55	206,405,706.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,773,200.00	26,290,200.00
210201	Тэтгэврийн даатгал	18,460,369.72	18,344,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	518,191.57	1,986,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	414,433.08	1,589,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	103,752.25	397,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,276,453.38	3,973,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,107,745.00	32,737,896.09
210301	Гэрэл, цахилгаан	5,146,895.00	5,177,237.19
210302	Түлш, халаалт	20,784,694.00	25,407,363.90
210303	Цэвэр, бохир ус	1,176,156.00	2,153,295.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,052,162.40	43,609,221.00
210401	Бичиг хэрэг	7,342,324.00	6,225,521.00
210402	Тээвэр, шатахуун	16,333,268.00	21,551,090.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,694,359.00	1,891,382.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	142,080.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,442,211.40	13,799,148.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,173,010.00	1,742,160.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	300.00
210604	Урсгал засвар	10,173,010.00	1,741,860.00
2107	Томилолт, зочны зардал	3,474,100.00	4,036,600.00
210702	Дотоод албан томилолт	3,474,100.00	4,036,600.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,666,213.00	11,636,644.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,065,484.00	10,837,715.00
210803	Даатгалын үйлчилгээ	320,675.00	358,920.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	110,974.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	70,000.00	174,356.00
210807	Газрын төлбөр	150,054.00	154,679.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	124,122,798.36	152,341,071.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	5,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	1,275,340.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	124,122,798.36	146,065,731.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,954,735.38	7,338,036.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,135,000.00	3,593,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,135,000.00	3,593,700.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,641,581.00	3,744,336.53
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,744,336.53
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	45,888,586.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	45,888,586.00
223001	Бусад хөрөнгө	00.00	45,888,586.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>26,892,369.64</u>	<u>86,625,200.69</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-117,926,412.22</u>	<u>86,625,200.69</u>

4.2 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>316,098,185.00</u>	<u>427,461,754.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,775,311.00	4,873,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,775,311.00	4,873,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,775,311.00	4,873,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,775,311.00	4,873,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	305,322,874.00	422,588,254.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,070,074.00	49,880,154.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,070,074.00	37,547,717.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	10,048,237.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	300,252,800.00	372,708,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	300,252,800.00	372,708,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>303,622,485.00</u>	<u>374,338,268.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	303,622,485.00	374,338,268.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	292,802,749.62	365,900,731.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	182,477,479.62	207,282,196.28
210101	Үндсэн цалин	180,727,479.62	207,282,196.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,773,200.00	26,290,200.00
210201	Тэтгэврийн даатгал	14,515,400.00	18,344,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,814,400.00	1,986,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,451,600.00	1,589,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	362,900.00	397,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,628,900.00	3,973,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,942,000.00	29,857,099.19
210301	Гэрэл, цахилгаан	5,146,895.00	5,177,237.19
210302	Түлш, халаалт	20,784,694.00	20,886,856.00
210303	Цэвэр, бохир ус	2,010,411.00	3,793,006.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,251,086.00	21,472,259.00
210401	Бичиг хэрэг	4,009,950.00	3,978,621.00
210402	Тээвэр, шатахуун	14,707,368.00	13,830,256.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,871,453.00	1,891,382.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,504,850.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,157,465.00	1,652,000.00
2105	Нормативт зардал	81,500.00	200,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	81,500.00	200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,682,255.00	3,540,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	512,000.00	1,215,100.00

210602	Тавилга	00.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	11,170,255.00	825,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,474,100.00	4,036,600.00
210702	Дотоод албан томилолт	3,474,100.00	4,036,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,196,129.00	66,323,007.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,655,400.00	65,284,078.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	230,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	320,675.00	368,920.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	110,974.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	70,000.00	174,356.00
210807	Газрын төлбөр	150,054.00	154,679.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,925,000.00	6,899,270.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,925,000.00	5,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	1,899,270.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,819,735.38	8,437,536.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000,000.00	3,250,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	3,250,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,641,581.00	5,187,536.53
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,641,581.00	1,443,200.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,744,336.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>12,475,700.00</u>	<u>53,123,486.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	12,475,700.00	52,073,486.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,475,700.00	52,073,486.00
2200	Дотоод эх үүсвэрээр	12,475,700.00	52,073,486.00
223001	Бусад хөрөнгө	00.00	45,888,586.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,475,700.00	6,184,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-12,475,700.00</u>	<u>-52,073,486.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	1,050,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	1,050,000.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	770,273,463.96	171,413,556.35	649,582,900.30	1,591,269,920.61
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	12,500,000.00	12,500,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	770,273,463.96	171,413,556.35	662,082,900.30	1,603,769,920.61
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	69,342,000.00	00.00	-117,926,412.22	-48,584,412.22
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	839,615,463.96	403,402,109.50	544,156,488.08	1,787,174,061.54
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	839,615,463.96	403,402,109.50	544,156,488.08	1,787,174,061.54
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-2,435,887.00	-2,435,887.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	839,615,463.96	403,402,109.50	541,720,601.08	1,784,738,174.54
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	86,625,200.69	86,625,200.69
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	839,615,463.96	403,402,109.50	628,345,801.77	1,871,363,375.23

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	377,698,100.00	373,837,263.47	3,860,836.53	98.9
УРСГАЛ ЗАРДАЛ	331,598,100.00	327,948,677.47	3,649,422.53	98.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	330,798,100.00	327,148,677.47	3,649,422.53	98.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	207,320,900.00	207,282,196.28	38,703.72	99.9
Үндсэн цалин	207,320,900.00	207,282,196.28	38,703.72	99.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,290,200.00	26,290,200.00	0.00	100.0
Тэтгэврийн даатгал	18,344,000.00	18,344,000.00	0.00	100.0
Тэтгэмжийн даатгал	1,986,600.00	1,986,600.00	0.00	100.0
ҮОМШӨ-ний даатгал	1,589,300.00	1,589,300.00	0.00	100.0
Ажилгүйдлийн даатгал	397,300.00	397,300.00	0.00	100.0
Эрүүл мэндийн даатгал	3,973,000.00	3,973,000.00	0.00	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,857,100.00	29,857,099.19	0.81	100.0
Гэрэл, цахилгаан	5,183,300.00	5,177,237.19	6,062.81	99.8
Түлш, халаалт	21,897,800.00	20,886,856.00	1,010,944.00	95.3
Цэвэр, бохир ус	2,776,000.00	3,793,006.00	-1,017,006.00	136.6
Хангамж, бараа материалын зардал	16,205,600.00	15,765,622.00	439,978.00	97.2
Бичиг хэрэг	3,650,800.00	3,301,240.00	349,560.00	90.4
Тээвэр, шатахуун	9,178,800.00	8,801,000.00	377,800.00	95.8
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,604,000.00	1,891,382.00	-287,382.00	117.9
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00	0.00	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,652,000.00	1,652,000.00	0.00	100.0
Нормативт зардал	200,000.00	200,000.00	0.00	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	200,000.00	0.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	4,325,000.00	4,325,000.00	0.00	100.0
Багаж, техник, хэрэгсэл	3,025,000.00	3,025,000.00	0.00	100.0
Урсгал засвар	1,300,000.00	1,300,000.00	0.00	100.0
Томилолт, зочны зардал	4,159,900.00	4,036,600.00	123,300.00	97.0
Дотоод албан томилолт	4,159,900.00	4,036,600.00	123,300.00	97.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,539,400.00	32,492,690.00	3,046,710.00	91.4
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	34,023,000.00	31,453,761.00	2,569,239.00	92.4

хураамж				
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	230,000.00	230,000.00	0.00	100.0
Даатгалын үйлчилгээ	550,000.00	368,920.00	181,080.00	67.0
Тээврийн хэрэгслийн татвар	276,400.00	110,974.00	165,426.00	40.1
Тээврийн хэрэгслийн оношлогоо	230,000.00	174,356.00	55,644.00	75.8
Газрын төлбөр	230,000.00	154,679.00	75,321.00	67.2
Бараа үйлчилгээний бусад зардал	6,900,000.00	6,899,270.00	730.00	99.9
Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,900,000.00	1,899,270.00	730.00	99.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	800,000.00	800,000.00	0.00	100.0
Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	800,000.00	0.00	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	800,000.00	0.00	100.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	46,100,000.00	45,888,586.00	211,414.00	99.5
Дотоод эх үүсвэрээр	46,100,000.00	45,888,586.00	211,414.00	99.5
Бусад хөрөнгө	46,100,000.00	45,888,586.00	211,414.00	99.5
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	377,698,100.00	377,581,600.00	116,500.00	99.9
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	372,698,100.00	372,708,100.00	-10,000.00	100.0
Орон нутгийн төсвөөс	372,698,100.00	372,708,100.00	-10,000.00	100.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,000,000.00	4,873,500.00	126,500.00	97.4
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	4,873,500.00	126,500.00	97.4

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.0	47,386,954.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.0	47,386,954.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.0	44,936,954.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.0	5,706,637.00
210401	Бичиг хэрэг	0.0	677,381.00
210402	Тээвэр, шатахуун	0.0	5,029,256.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.0	1,500,000.00
210602	Тавилга	0.0	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.0	37,730,317.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.0	37,730,317.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.0	2,450,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.0	2,450,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.0	49,880,154.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.0	49,880,154.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0	37,547,717.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.0	12,332,437.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	1,050,000.00